



ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 511

Биндэр сум

Т.Батбаярыг ажилд
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 47 дугаар зүйл, 49 дүгээр зүйл, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Түгжээгийн Батбаярыг 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс Засаг даргын тамгын газрын жолоочийн ажилд томилсугай.
2. Т.Батбаярыг сарын үндсэн цалинг ТҮ-3 зэрэглэлээр тогтоон, 1052000 (нэг сая тавин хоёр мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д зөвшөөрсүгэй.
3. Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Т.Батбаярт үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ӨНӨБОЛД

